

ОЛОН УЛСЫН ТАВЦАН ДАХЬ ШАШИН ХООРОНДЫН ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ

С.Т. Амиргазин - Лев Гумилевын нэрэмжит Евразийн Үндэсний Их Сургууль, Астана, Казахстан Улс, доктор, дэд профессор

Олон улсын аюулгүй байдал болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын шашны конфесси хоорондын хариуцлагын тухай судлагдахуун нь зөвхөн өнөөдөр биш, өнө эртнээс нааш хөндөгдөж буй асуудал юм. Өөрийн гэсэн өвөрмөц чанартай шашны үзэл санааны одоогийн олон улсын тавцан дахь байр суурь өдрөөс өдөрт өсөх хандлагатай бөгөөд харилцааных нь хувьд улс төрийн үйл явдалтай холбож өөртөө оноо нэмэхээр тэмүүлэгчид их байсан ба цаашдаа ч байх болно. Бидний зорилго энэхүү маргаантай асуудалд НҮБ зөв шийдвэр гаргахад нөлөө нэмэр болох концепци гаргах явдал юм.

Ер нь XIX зууны II хагаст шашин судлалын харьцууллыг голландын шашин судлаачид П.Д.Шантепи де ла Соссе (1948-1920) ба К.П.Тилегийн (1830-1902) бүтээлүүдээс мэдэж болно. Шашин судлалын факультет дэх өөрчлөн шинэчлэлийн ачаар Нидерландад 1876 онд Францийн Коллеж де Франс гэдэг их сургуульд, дараагаар Швецари, Их Британ ба Нэгдсэн улсуудад ийм маягийн тэнхимүүд нээгдэн ажиллажээ.

Харин Казахстаны байдлыг түүхийн үүднээс авч үзвэл атеист үзлийг тооцолгүйгээр зөвхөн 1993 онд Казах Улсын Үндэсний Их сургуулийн философи ба улс төрийн факультетэд шашны онол ба түүхийн тэнхим нээгдэж, дараа нь «шашин судлах тэнхим» хэмээн нэрлэгдсэн билээ. Яг энэ үеэс эхлээд их сургуулиудад ийм нэртэй тэнхимүүдийн тоо өсчээ.

Шашин судлаачдын анхны Конгресс 1897 онд Стокгольм хотод, шашны түүхчдийн Конгресс Парис хотод 1900 онд болсон юм. Саяхны жишээг иш татвал 1998 онд «Дэлхийн шашны Парламент» өөрийнхөө ажлаа эхлэв. Энэ нь шашны улс хоорондын нөлөө сайжирсны болон тэдний гол асуудлуудыг шийдвэрлэх орчин үеийн шинэ боловсролын чиглэл юм.

Казахстан улс конфессилэг ба шашны нэгдлүүдийн маш том төрөлтэйгээрээ өвөрмөц талтай. Үүний учир нь Казахстанд 100-гаас илүү үндэстэн, ястан оршин суудагтай холбоотой юм. Гэхдээ сүүлийн жилүүдэд урд өмнө байгаагүй шашны элдэв үзэл санаа ихэссэн. Урд өмнө ажиллаж ирсэн шашны нэгдэлүүдийн хамт улсын газар нутагт Европын, Америкийн захиргаа суурьгүй хэмээн нутгаасаа хөөсөн зарим шашны сектүүд ч Казахстан улсад ирээд өөрсдийн үзэл бодлоо нууж хаалгүй ил явуулах болжээ.

Энэхүү гаднаас ирсэн миссионерүүдийн ихэнх нь хасаг түмний сул талыг, эдийн засгийн хямралыг ашиглан ухуулгаа явуулж байна. Манай улс эрх чөлөөт улс байгуулахын дагуу иргэний нийгэм байгуулахыг зорилго болгосон энх тайван, тэгш эрх чөлөөг эрхэмлэсэн улс билээ. Тийм ч учраас олон улсын хүний эрх чөлөөний тухай хуулийн хэм хэмжээний ардчилсан талыг өөрсдийнхөө хуульд жишээ болгон тусгаж авсан юм. Гэхдээ бид ардчилсан үзэл санааг дагаад байлгүй өөрийн гэсэн улсын, үндэсний хууль гаргах ёстойг мартаж болохгүй. Үүнд шашны байдалд хамаатай асуудал бол ёс суртахуун юм. Жишээлбэл, Кудайбердийн Шакарим «Гурван ил тод» нэртэй философийн бүтээлдээ энэхүү ёс суртахууны асуудлууд казах ахуйн ба оюуны бүтэн бүрэлдэхүүнийг гаргаж өгсөн билээ.

Хувь хүн, нийгэм, олон нийтийн ба сэхээтэн байгууллага ба улс хоорондын «гүүр» болох шашин одоо үед янз янзаар ашиглагдаж байна. Шашны факторын соёл дахь орон нь ч гэсэн тохиромжгүй байдалтай. Постиндустриал үйлдвэрийн үе хэмээн нэрлэгдэж буй үед шашны ухамсар ба ёс суртахуун, эрх чөлөө асуудал нь олон улсын байдлаас эхлээд хувь хүнийг хүртэл сайтар олон талаас шинжилэгдэж байна. Учир нь одоог хүртэл хүний яг төрхийг тодорхойлдог тодорхойлолтууд манай энэ үед маш ихдэж байна гэж бодож болно. Жишээ нь эрт үед Аристотелийн хэлсэн «Хүн бол инээж мэддэг амьтан» танин мэдэхүйгээс эхлээд хүний ахуйн төрх гэсэн ихээхэн зүйрлэлүүд байсан. Софистүүдийн үед бий болж дараа нь антропологийн баримтлал болсон «Хүн бол бүх юмсын хэмжүүр», «Хүн бол соёлтой амьдрагч», «Хүн бол оюун санааны эзэн», «Хүн бол хөдөлмөрийн үр дүн мөн», «Хүн бол эволюцийн дээд оргил», «Хүн бол Аллахын хайртай хүмүүн», «Хүн бол нийгмийн хувь хүн мөн», «Хүн бол нийгмийн харилцааны үр дүн мөн», «Хүнлэг харилцаа бол улс төрийн бүтээл мөн», «Хүн бол мэдрэхүйн боол» гэх мэт маш олон тогтолцоот үзлүүд хүний ахуйд өөрийн гэсэн ийм дүр өгөх гэж оролдож байв. Үнэхээрийн эдний аль алин ч гэсэн хүний ахуйд тусгасан нэмэртэйн дагуу үүсгэсэн асуудлууд ч ихээхэн юм. Түүний дотор «Хүн итгэлтэй төрөлхтөн мөн» гэсэн гол санаа нь өөрийн тэмүүлээрээ хүмүүн хичнээн зуун амьдарсан ч төчнөөн хугацаа хамт ирсээр байна. Үүний гол асуудал ёс суртахууны асуудлын одоо хүртэл боломжтойн хэмжээгээр шийдвэрээ олоогүй явдал юм.

Орчин үеийн шашны нийгмийн харилцаан дахь авах орон нь түүний мэдлэг боловсрол авах, улс төрийн, эдийн засгийн, сэтгэл зүйн социологийн амьдралтай нягт холилдон өөрийн гэсэн шийдвэр санал тавьдагтай холбогдолтой болоод байна. Түүний дагуу шашны улс төрийн бодлого ба идеологийн зэвсэг болж байгаа явдал нь олон нийтийн буруу санал төрүүлж байна. Улс төрийн ашиг сонирхоллын талаар бол нэг улсад магадалгүй болох ёс суртахууны эрх чөлөөний байдал өөр нэг улсад түүний улс төрийн аль эсвэл нийгмийн эдийн засгийн тэмүүлэлийн дагуу хувирахаас өөр аргагүй. Энэ ч гэсэн одоо үеийн үнэн байдал. Яагаад гэвэл ёс суртахууны эрх чөлөөг өөрсдийнхөө нам, нэгдэл, деноминацийн, конфессийн ашиг сонирхолдоо тохируулж ашиглагчид ихдээд байна. Тэгээд ч бас шашны ухамсарын нийгмийн хоорондын, улс хоорондын, үндэстэн хоорондын зөрчилд ч холилдуулах гэсэн улс төрчид ч ихээхэн байдаг. Ямар нэгэн эдийн засгийн, социологийн, улс төрийн аж байдлыг хэлж байтлаа өөрийн ашиг сонирхолоо биелүүлэхээр тэмүүлэх ямар ч шашны сургамжийн хувьд байхгүй ч тухайн үеийн урсгалын дагуу ийм үзэгдэлүүд байсан ба цаашдаа ч байх болно. Тийм учир манай улсад өөрийн гэсэн өвөрмөц талаараа зохиж буй ёс суртахууны эрх чөлөөт байдлыг тогтмолжуулбал нэг их алдахгүй байх гэж үзэж байна.

Түүний дагуу шашины холбогдолтой тавигдах хүнлэг шаардлагуудын ч тэмүүлэл бүрмөсөн өөрчлөгдсөн. Шашинд бишрэх ба шашин шүтэхээс гадна шашингаас өөрийн ахуйд чухал зүйлсийн түргэн шийдэгдэхийг дотроосоо шаарддаг тенденци үүсвэрлэсэн. Шашныг уламжлалт ёсоор хэрэглэхийг баримтлагчидийн тоо соёлын ба оюун ухааны шаардлага нь ихдэж, шашинаас практикийн тусламж хүлээгчидээс бодвол маш хурдан цөөхөрсөн юм шиг. Энэ бол нэг талаас захын эдийн засгийн шаардлагуудын дагуу шинэ санаачилгыг эзэмшин боловсруулахын, оюун ухааны салааны идеологийн боолтоос суллагдаж шинэ оюун дүгнэлт хийснээс, ухамсарын хурдан тусгаж авахаас шалтгаалагдана. Үүнээс гадна шашины урсгалууд ч цаг хугацааны шуурхайн дагуу үзэл сургамжуудадаа өөрчлөн байгуулалт оруулж байхыг мартаагүй. Харин орчин үед энэ талаар уламжлалт конфесүүд өөрсдийнхөө тэмүүлэлдээ үеийн урсгалыг дагаж чадаагүй.

Шинээр үүсэж эхэлсэн демонацууд бол одоогийн хүний доторх сэтгэхүйн хүсэлтийг яг олж хэрэгцээнүүдийг нь хангахын арга замыг олж мэдсэн. Тийм ч учраас тэдний дотор агрессивн, харизмын, радикалын, экстремисийн урсгал дахь үзэл сурталууд маш их тааралддаг. Энд ёс суртахууны эрх чөлөө биш, моралийн, иргэний, эрхийн процесүүд шийдвэртэй зам хайх ёстой.

Шашны нэгдэлүүдийн нийгмийн оюун ухааны сэргэн мандалтын оюуны ахуйн дэлгэрэхийн, үндэсний уламжлал ба шүтлэгүүдийн (өрістеуінде) хөгжилд гол үүрэг гүйцэтгэж чухал орон эзэлдэгийг дээр дурдсан билээ. Шашны үзэл сурталын ихэнх нь хүнлэг ёс суртахууны сургамжууд нь нийгмийн амьдралд сайн талаар нөлөөлөх нь гарцаагүй. Гэхдээ дээр дурдсантай адил хурдан хугацаанд үр дүн хүлээж болохгүй. Учир нь:

1. Шашин ба шашны сургамжууд манай нийгийн бүх гишүүдэд адил хэмжээгээр нөлөөлдөггүй.
2. Хүмүүжлийн нөлөө маш урт бөгөөд нарийн хугацааны чадалд харгалзаж байдаг.
3. Бидний ажиглалтаар бол ихэнх хүмүүст шашны ухамсар зөвхөн зан үйлдэлийн дүрмийн хэмжээгээр л хөгжисэн шинжтэй бөгөөд оюун ухааны хувьд нэг их өөрчлөлт оруулж чадаагүй.

Тийм ч учир ораза айт барьдаг хүмүүсийн ихэнх нь түүнийг баяр баясгалын байдалд хувиргасан байна. «Ауыз ашар» үйлдэл нь ямар нэгэн алба, үүрэгтэй төстэй болжээ. «Өнөөдөр хэн ауыз ашард дуудах бол» гэсэн байнгын хүлээлт бий болсон юм шиг. Энэ бол мусулман сургамжийн суурьт гэсэн хайнга хандлага мөн. Түүний дагуу орой нар жаргавал боллоо ямар ч хорио байгүй, аль эсвэл «орзаг өдөр болгон биш, Кадырын шөнөд ба хэдэн өдөр л баривал болдог юм байна» гэсэн буруу саналууд мусулманчлалд байх ёсгүй юм. Энэ бол шашны орнууд нь – мешит, сүм хийд, синегог нь орчин үеийн соёлын ба ёс суртахууны ямар ч хариуцлага өөртөө аваагүйн шинж. «Бүх юм Аллахын гарт», «Человек предполагает, а Бог располагает» гэсэн сайхан үгсийг хэлж, гаргаж өгөхийн хэрэггүй. Ер нь зөвхөн хувь хүмүүс ба тусгай шашны сургуулиудыг төгссөн мэргэжилтэнгүүд гүйцэтгэдэг нь ойлгомжтой. Түүний дагуу зарим шашны нэгдэлүүд ийм үүрэгтэй, жишээ нь «Иеговагийн гэрчүүд» мэтүүд мөргөгчүүдийг өөртөө татан, бүр үүргийг алба ёсонд хувиргаад байна. Энэ нь өөрийн эрх хэмээн зарлагдсан ч хувь хүний ёс суртахууны чөлөөнд шашны нэгдэлүүдийн хувиас гарч буй хавчилга гэхээс өөр аргагүй. Тийм учираас улс орны талаас шашны нэгдэлүүдээс тэдний үйл ажлын тухай тодорхойлолт авах ёстой ба түүнтэй адил демократийн, принципийн дагуу хуулийн нормыг үүсгэх хэрэгтэй. Харин зарим шашны урсгалуудын ёс суртахууны нормууд улсын моралийн нормуудтай санаа нийлдэггүйг мартаж болохгүй. Тэр учир үүнийг төлөвшүүлж, тусгай заадаг-шашин судлалын шинжлэх ухаан гэдгийг тайлбарлах ч илүүдэх байх. Дунд сургуулиас эхлээд лицей, колледж, дээд, их сургуулиудад шашин судлах хичээлийг «шагын багдарламалар» тусламжаар оруулах шаардлагатай.

Православийн философич И.А.Ильиний энэ нэгэн хэлсэн үгийг жишээгээр авч үзвэл: «ибо нет ничего соблазнительнее, как принят влечение своего инстинкта, или похоть своей воле, или интерес своей человеческой особы – за указание или повеление Бога, укрылся за этот шаг и предаться упорству и неистовству своих хотений, во исполнение якобы «предписаний Всевышнего»» гэх нь шашны нэгдэлүүд хоорондох харилцааны хариуцлагийн асуудлыг улсын хувиас тайлах хэрэгтэй гэдгийг үзүүлж байгаа юм биш үү. Хүн төрөлхтний түүх ба шашны түүх иймэрхүү хувьсалтай сайн танил юм. Шашны төлөвийг хувиргах буруу санаачилга, хуурамч бурхны элчүүд, өөр шашны үзэлд

гэсэн тэвчээргүй хандлага, шашин хоорондын байлдаан маш их. Бүр одоо үед ч эдийн засгийн байдлаараа муу улсууд ба индустрийн хөгжисөн улсуудын хоорондох, хэвлэл мэдээлэлийн орон зайг эзэмшигчид ба хэвлэл мэдээлэлгүй үлдсэнгүүд хоорондох улс төрийн маргаанд шашны ухамсарыг, шашны чиглэлүүдийг улс төрчлөн олон улсын харилцааг өөрийн ашиг сонирхолын төлөө зөрчилдүүлэхийг чармайж суугчид ч бий.

Шашин термин нь бол уламжлалын этимологийн ойлголт дахь «холбох» ойлголтыг нь авч үзвэл, орчин үеийн мэдээлэлийн орон зайн олон төрлийн хэрэгсэл Интернетийн холбоо дахь шашны мэдээлэлүүдийн сайтыг харвал энэхүү холбоотой төстэй болсон байхыг анзаарч болно. Яагаад гэвэл, 1982 оноос эхлээд Интернетийн сайтанд «Интернетээс Бурханыг яаж олж болох вэ?» гэсэн илтгэл гарсан билээ. Үүнд шүтээн бичээсүүд (Коран, Инжил, Таурат, Упанишада) ба энэ номнуудад хамаарагдах санал бодлууд өгөгдсөн байх юм. Түүний дагуу янз бүрийн уламжлалт ёсонд үл хамаарагдах шашны конфессүүд ба деноминацийн – мармонуудын, сатанчуудын, Мари Деви Христосын үе залгамжлагчуудын сургаалуудын тухай мэдээлэлүүд хамаарагдсан. Энэ Интернетийн сайтаас явагдсан асуулт хариултаас ийм дүгнэлт гарсан байна. Асуулт хариултад оролцогчидийн 65,7% нь шашинд бишэрдэг, 55,8% нь хойд ертөнцийн байдагт итгэдэг, 36,7% нь шашны бишрэлийг хувь хүний эрх чөлөө гэж үздэг, 46,1% нь энэхүү холбоог ашигласнаас хойш өөрсдийнхөө шашинд гэсэн дур хандлага ихдэсэн байхыг мэдээлэлжээ. (Бабаев М. Новые боги. Религия в киберпространстве: универсальный медиум. Газета НП, №6, 2002г.) Үүнээс бид орчин үеийн мэдээлэлийн технологийн хөгжилт нь шашны бишрэлийг өсгөхөөс биш багасгадаггүйг тодорхойлж болох юм. Гэхдээ үүний өвөрмөц тал нь шашны бишрэлийн өсөх нь шашны догмууд ба доктринууд биш, бурхантай шууд харилцаа байгуулахын дагуу гүйцэтгэдэг нь юм. Иймээс Интернетээс орж ирдэг шашны сургамжийг ашиглагчидийн сонгох боломжийг бүхэлээр нь өөрсдийнхөө эрхэнд үлдээх хоёр талаараа нөлөөлж магадгүй. Нэгдүгээрт, шашны үзлүүдийн санал бодлын их төрөлтэй байх нь «Хичнээн хүн амьдарвал – Бурханд аваачих зам ч төчнөөн их» ойлголтын дагуу явдаг бол, хоёрдугаарт, шашны ойлголт хүнийг мухардуулах байдалд оруулж магадгүй. Ийм гэдэг нь «Хэрвээ үнэн иймэрхүү их юм бол ямар ч үнэн байгүй гэсэн үг, бүгд харьцангуй, өнгөрөмтгэй ба худал» гэсэн ойлголтонд тулж байна. Тэгээд ч сүм хийдийн, мешитийн үндэслэлт ухуулгын орныг мистиклэг үзлүүд шахаж гаргах ч үе ирсэн бололтой. Үүнээс гарах үр дүн бол шашны хариуцлагыг ухамсар, оюунлаг нийгмийн, олон улсын, хувьд үндэслэе гэвэл мэдээлэлийн хүрээлэн дэхь шашны ухуулганд хамаатай хариуцлагын асуудлыг анхаарлаасаа гаргахгүй байх нь нийгмийн хэрэгцээ мөн. Үүний дагуу олон улсын аюулгүйн асуудалд мэдээлэлийн аюулгүй байдалд хамаарагдах шашны үзэлүүдийн ёс суртахууны чөлөөг хамгаалах хуулийн нормууд хуулийн ёсоор дүгнэгдэх хугацаа иржээ. Тусгаар тогтнолт манай улсын өмнөх томоохон үүргүүдийг гүйцэтгэхийн тулд биелэх ёстой нь бол: «нэгтгэн дүгнэвэл, улс төрийн аль эсвэл шашны, үндэсний экстремизм эзлэх зайгүй улс байгуулах» гэдгийг санавал, олон улсын аюулгүйн асуудал дахь шашны хариуцлагын эзлэх орныг үеийн шаардлагт зохих хэмжээгээр үнэлэх мөн.

Хүн төрөлөхтнийг хамгийн эхэлж нийгмийн соёлын феномен үүднээс харж үзэх нь түүний онтологийн эсвэл космосын феномен чанартай холбогдолтой. Шинжлэх ухаан ба технологи хөгжилтийн оргилд хүрсэнд ба хүн төрөлхтний нэг нэгийгээ хялбар таних боломжтой болсоныг харгалзахгүйгээр сүүлийн үед шашны экстремизм, терроризмийн сэдэв хэвлэл мэдээлэлийг эзэмшиж байна. Жинхэнэ экстремисийн бүлгүүдийн гайг баруун хойны улсууд үзэж байна. Сүүлийн жилүүдэд АНУ, Европийн улсуудад их тарсан

христианы фундаменталийн байгуулагууд ба олон төрлийн сектүүдийн шалтгаанаас болж мянга түмэн хүмүүс өрөвдөлтэйгээр үрэгдсэнийг мэднэ. Жишээ нь АНУ, Калифорнийн Сан-Диего хотод «Их булаг» хэмээн нэрлэгдэх сектийн 39 гишүүн 1997 оны 3 сарын 26 нд амиа хорлосон. 1978 оны 11 сарын 18 ны өдөр Баруун Америкийн Гаяна улсын Джеймстаун хотод сектийн «Ардын сүм» 912 гишүүн цианы газаар өөрсдийгөө хорлож үрэгдсэн байна. Францийн Сен-Пиер хотод «Наран сүм» сектийн 16 гишүүн 1995 оны 12 сарын 23 нд өөрсдийгөө шатаасан. Энэ сектийн Швецарийн хоёр хотод буй гишүүд 1994 оны 10 сарын 5 нд бас ийнхүү шатаж үрэгдсэн. Америкийн Техас штатын Вако хотхонд «Давидиан» сектэнд 80 хүн 1993 оны 4 сарын 19 нд мөн өөрсдийгөө шатааж үрэгдсэнийг дэлхийн хүн төрөлхтөн одоо болтол мартаагүй байх ёстой. Филиппин дэхь монах Датү Мангайани сектийн акцияд 1985 оны 9 сарын 19 нд 60 хүн өөрсдийгөө хортой газаар амиа хорлосон байна. Сүүлийн үед Дундад Африкийн нэг улсад католиг сүмийн хэдэн мянган гишүүд хамтаар амь өгөх үйлдэл хийжээ. Энэ мэт явдалууд нь сектийн үйл хэрэг ба тэдний худал мунхаруулгад итгэсэн гэнэн ардын амь үрэгдэх нь маш харамсалтай. Шашны конфессүүдийн хоорондын хариуцлагын нэг булан нь бол өөрсдийнх нь конфессийн дотор үүсэж, сүүлдээ уй гашуунт явдалтай нийцэж байдаг үйлдэлүүд юм. Ер нь улс хоорондын ажиглагч байгуулагуудын ажлуудыг энэ асуудалд зохих хэмжээний санаа тавихыг үүрэглэх хэрэгтэй гэдгийг ойлгох цаг болсон юм байна.

Сүүлийн үед хэвлэл, телевизийн нэвтрүүлгүүд ба радионы мэдээнд орос хэлнээс орсон «фундаментализм» гэсэн үг маш их тааралддаг. Энэхүү хэвлэл мэдээлэлд фундаментализм үг нь ихэнхдээ мусулман шашинт улсуудад л хамааруулж хэрэглэж байгаа нь учиргүй буруу санал бодол төрүүлэх нь тодорхой. Энэ мэдээлэлүүд «исламын фундаменталчууд» эсвэл «мусулманчуудын хуулиас гадна аюултай байгуулагууд ба муу нөлөөт үйл ажиллагаанууд» хэмээн балмагдаж байна. Энэ асуудлыг өмнөх бүлгүүдэд сэдвийн дагуу өгүүлсэн билээ. Үүнд дахин эргэхийн гол учир нь энэ мэдээлэлүүдийн өөрт нь хамаарагдах хариуцлагын арга хэмжээ Нэгдсэн Улсын Байгууллагын эсвэл түүний хариуцлагаар тэнцэж чадах олон улсын байгуулагуудын энэ асуудлыг тавьсанаар шийдвэрлэгдэх ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл фундаментализм мусулманчуудтай ямар ч хамаа холбоогүй ойлголт. Християн ертөнцийн ялангуяа Зүүн Америкийн ба Хойд Европын християнчуудын өөрийн хоорондын оюун ухааны зөрчил ба байлдааны шалтгаанаас бий болсон нэрийг, энэ бүхэн явдал мусулманчуудад байгаа байх гэж андуурч хэрэглэсний улмаас одоо үед шашны улс төрийн зэвсэг болоод байна. Ер нь үүний эх орон АНУ юм. Тэр ХХ зууны эхэнд АНУ-н зүүн хэсэгт үүссэн ургал билээ. Хоёр мянгаас илүү сүмийг эзэлсэн тэд өөрсдийгөө «Фундаменталч християнчууд» хэмээн нэрлэсэн шашны экстремист урсгал юм. Олон нийтийн үйлдвэрийн ажлаас, түүнээс гадна аж ахуйн хоосролоос маш их зүдэрсэн зуун мянгаад християнчууд эрх чөлөөг энэ сүмээс хайж зугларсан байна. Тэд Инжилийн утганд үг үгээр нь сайн бишрэхээр суурьлагдсан гэж тооцологддог протестант урсгал. Америкийн фундаменталчуудын анхны улс төрийн маргаан 1963 онд эхэлсэн байна. Тэр жил Америкийн Дээд Шүүх сургуулиудад шашны хичээл заахыг хоригложээ. Фундаменталчууд «дэлхийч гуманизм» гэсэн шинэ нэгэн шашин тарах гэж байна» гэсэн уриагаар энэ зарлигт эсэргүүцэл үзүүлэв.

Одоо америкийн нэрт фундаменталчуудын тухай асуудлыг ч харж үзье. 1992 онд сонгуулд Джорж Бушт «Християнчуудын эрхүүд» нэрэмжтэй байгуулга тусалсан юм байна. Хоёрдахь фундаменталч байгуулга Джерри Фальвеллийн удирдлагаар «Оюун ухааны түмэн» хөдөлгөөн байсан. Гуравдугаар байрыг Пат Робертсонд харгалзаддаг «Християн холбоот» эзэлсэн. Эдний дараах байруудыг зуун мянган гишүүтэй хоёр

нийгмийг нэрлэж болно. Луй Шелдоны удирдлагаар «Уламжлалт үний нийгэм» ба Лон Мабоны удирдлагаар «Иргэнүүдийн нэгдэл». Үүний дагуу «аврагч үйл ажиллагаа» (аборт хийлгэгчүүдтэй өршилдөөн) байгууллага нь дээр дурдсан байгууллагуудад тусалж байдаг. Тэгээд ч Америкийн «Тайм» сонины 1995 оны 5 сарын 8 өдрийн дугаарт том илтгэлд сэдэв болсон фундаменталч үзэлтэй иргэнүүдийн хувиас үндэслэн тавигдсан «Эх орончуудын зэвсэг» нэртэй идэвхтэнгүүдийн хуулиас гаднах зэвсэгүүдийг нь хэлж болно. Тийнхүү тэр өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын хамгийн том аюултай бүлэгүүд бүх ард түмнийг нийтээр нь устгахаар оролджээ. Тиймээс америкийн шашны экстремистүүдийн тухай мэдээлэл маш их тарсан юм. Бидний зорилго олон улсын хэмжээний шашны конфесси хоорондын хариуцлага юм болохоор олон улсын эрх чөлөөний нормын дагуу өөрийн гэсэн санал бодлоо тавих л юм. Түүний хамт, ийм байгууллагуудын манай улсад төлөвшиж буй шашны нэгдэлүүдийн хооронд үүсэхгүйд хэн ч баталгаа өгч чадахгүй. Бид хариуцлагын асуудлын хамгийн нарийн нь шашны хариуцлага юм гэдгийг дахин нэг тодорхойлсон бололтой.

Энд бид өөрсдийнхөө уламжлалт шашин гэж тооцолдог мусулманчлалын, түүний соёлын өргөн их хязгаарт ба боломжуудын хязгааргүйд өөрийн эрхгүй талархахаас өөр аргагүй юм байна. Бусдын ч яахав хүний эрхийн тухай зарлиг XX зуунд л шийдвэрлэгдсэнийг бодвол, арван дөрвөн зууны өмнө Куран Каримд бүх хүний эрхийг хамгаалах үүргийн зарлиг гарсаныг үзэж болно. 26/183: Хүмүүсийн эрхийг бүү хавчигтун! Газар дээр бүү танхайрч, зөрчилдөөн бүү гаргагтун! Ийнхүү ихээхэн аят, хадис, дүрмүүдийг авч үзвэл, мусулманчлал эрт үеэс олон төрлийн шашин хоорондын хариуцлагын асуудлыг тодорхойлж өгсөн байна. Орчин үед дэлхийн бүх оршин суугчидийн санааг зовоож буй олон улсын аюулгүйн асуудалд шашны хариуцлагын оюун ухааны үүрэг гүйцэтгэдгийг үүгээр тогтохоор шийдлээ. Яагаад гэвэл, гол зорилго бол энэ асуудлыг шийдэхийн замуудыг харуулж, санал хэлэх биш, түүнийг цагийн хувиарт оруулах ба олон улсын байгууллагын хоорондох (пикирталас) ба дугуй ширээ (өткizuine мұрындық болу).

Түүний хамт улсын орган байгууллагууд шашны нэгдэлүүдийн хүсэл нэхэлтүүд, тэдний бүх хэрэгцээг хангах асуудалд маш анхааралтай байдлыг баримтлах хэрэгтэй. Учир нь Марксийн үгээр хэлвэл: «шашны олон нийтийн төлөө ихэнхийн хувьд опиумлаг нөлөө» болдогийг мартаж болохгүй. Хүн төрөлхтөн моралийн хувьд шашингаас өндөр хэмжээний зэвсэг олсонгүй гэвэл яг энүүнд харш факт - шашинч фанатикээс илүү зоригтонгуудыг ч олж гаргаж чадаагүй. Тийм учраас зарим шашны нэгдэлүүд ба улсын байгууллагууд хооронд зөрчил байж болох юм. Үүнийг болгохгүйн зам бол улсын ашиг сонирхолын дагуу өөрийн хоорондох хариуцлагын асуудлыг хамтарч төлөвшүүлэх хэрэгтэй. Хамгийн гол нь улс ба шашны нэгдэлүүдийн хооронд болж байдаг өршилдөөнг хэтэрсэн хэцүү байдалд оруулахгүй байх асуудлыг харж үзэх хэрэгтэй. Энүүнд түүхийн ил хувь хүний нийгмийн санал ба нийгмийн хөдөлгөөнд нөлөөлөхийг санах нь зүйтэй. Зарим шашны удирдах үүргийг гүйцэтгэдэг шашны нэр төртэй хүмүүстэй харилцааны үүргүүдийг хянаж, улсын хэмжээний тэнцвэртэй болгох хэрэгтэй. Улсын хуулиудын ашиг сонирхлол шашны нэгдэлүүдийн ашиг сонирхлолтой тооцоо хийж, тэдний улсын хуулиудыг сайн биелүүлж хянаж суух удирдлагат байгууллага байгуулах хэрэгтэй. Үүний ёс суртахууны эрх чөлөөнд өчүүхэн ч саад болохгүйд итгэж байна. Дүгнээд ирэхэд энэ бүх санал бодлууд Нэгдсэн Улсын Байгууллагын хувиас өргөмжлөл олж, олон улсын аюулгүйн асуудалд шашны конфессуудын хоорондох харилцааны хариуцлагын улам сайжируулахад

нэмэр болж, өөрийн гэсэн зохицуулан удирдах албаа улам сайжруулан цаашид үр бүтээлтэй үргэлжлүүлнэ гэдэгт итгэж байна.

Резюме

В данной статье рассматривается одна из актуальных проблем современности, то есть межрелигиозная толерантность и международной безопасности. Автор раскрывает основные аспекты религиозной ответственности.

Absract

In this article viewed one of the actual modern problems as a tolerance between all of world religions and security or safety of the world. The Autor disclose main aspects of religion responsibility.

Зохиогчийн тухай

Серик Амиргазин бол Казахстаны нийслэл Астана хот дахь Лев Гумилевын нэрэмжит Евразийн үндэсний их сургуульд багшилдаг, философийн шинжлэх ухааны дэд доктор, дэд профессор хүн. Тэрбээр философийн мэргэжилтэй шашин судлаач юм. Түүний бичсэн шинжлэл судлагааны өгүүлэл, бүтээлүүд Казахстан улсын олон арван сэтгүүл, хэвлэлд нийтлэгджээ. С. Амиргазин шинжлэх ухааны докторын зэрэг горилогч судлаач ажээ.